| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 2,333,555.49 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Батлагдсан төсөв | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | 37,952,676.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | 37,952,676.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 37,952,676.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 1,184,512.00 |
| 210101 | Үндсэн цалин | | 1,184,512.00 |
| 210102 | Нэмэгдэл | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 3,942,807.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 3,942,807.00 |
| **2105** | **Нормативт зардал** | | 1,236,050.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 607,550.00 |
| 210502 | Хоол, хүнс | | 628,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | |
| 210702 | Дотоод албан томилолт | | 227,057.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 462,250.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | 462,250.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 30,900,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 30,900,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | |
| I | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 38,431,229.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 31,647,529.00 |
| 131106 | Хаагдсан данс | | |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | | 6,783,700.00 |
| III | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 478,553.00 |

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөхморьт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Сүнжидмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бужинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 7 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөхморьт сумын Эрүүл мэндийн төв нь: Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг цаг алдалгүй иргэд хүргэх үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг болгодог хууль тогтоомж болон бусад бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Мөн Монгол Улсын Засгийн газрын 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан байхгүй байна. Дотоод хяналтын үр нөлөөг сайжруулан ажиллах шаардлагатай байна. Иймд дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөхморьт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 501.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 10.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 8.0 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 762.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 15.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 12.2 сая төгрөгөөр тогтоогдож байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөхморьт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16.2 хувиар буюу 71.6 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэлгүй, 2.8 сая төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй байна.

Авлага дансны эхний үлдэгдэлгүй, тайланд онд 85.3 сая төгрөгийн авлага нэмэгдсэн бөгөөд эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн болон эмийн авлага байна.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Өглөгийн үлдэгдэлгүй тайланд онд эмийн 52.1 сая төгрөгийн, хоолны 2.7 сая төгрөгийн нийт 54.7 сая төгрөгийн өглөгтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 41.5 сая төгрөг болж 17.0 сая төгрөгөөр өссөн нь ковид-19 цар тахлын хүрээнд Эрүүл мэндийн газар болон иргэдээс өгсөн хандив тусламж нэмэгдсэнтэй холбоотой.Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 145.5 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, 147.3 мянган үнэ төлбөргүй хөрөнгө орлогоор тайлагнаж, үйл ажиллагаандаа 275.6 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 440.2 сая төгрөг болж буурсан нь 42.0 сая төгрөгийн хөрөнгө акталсан мөн хөрөнгийн элэгдлийг зардалтай холбоотой. Тайлант онд 4.1 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч хандив тусламжаар 28.8 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр бүртгэж авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 515.0 сая төгрөг болж -21.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 155.5 сая төгрөг болсон байна.

## 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 398.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 14 сая төгрөгөөр өсгөж, 412.0 сая төгрөгөөр баталжээ.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 2 хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээг улсын болон орон төсвөөс санхүүжүүлэхээр 412.0 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 412.0 сая төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 27.1 сая төгрөг авч, нэмэлт санхүүжилтийн дансанд 38.4 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 4.0 сая төгрөгийн нийт 481.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 474.5 сая төгрөгийг зарцуулж, 0.2 сая төгрөгийн тогтмолын зардлын үлдэгдлийг татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 440.5 сая төгрөг буюу 99.0 хувьтай зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 38.4 сая төгрөгийн орлого хүлээн авсан байна. Сорьц тээвэрлэлт, сүрьеэгийн тандалт хийсэн томилолт, урамшуулал, дархлаажуулалтын зардалд тус тус зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн орлого, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааны тулгалтыг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулах 28 мэдээллээс, 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Горим сорил хэрэгжүүлсний үр дүнд шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар тендерт шалгараагүй иргэн аж ахуйн нэгж байгууллагаас 46.9 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна" гэсэн заалттай нийцээгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна. Мөн төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт үр дүн нөлөө-д хийсэн нийцлийн аудитаар өгсөн 6 албан шаардлагын шийдвэрийн хугацаа болоогүй байна.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

**Дараагийн жилийн аудитаар:**

1. Тээвэр шатахууны зардлын давтан үзэх
2. Төсвийн хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгийн чанар, ашиглалтын байдал үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 212.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 104.3 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 1.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 106.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1 заалт зөвлөмж хүргүүллээ.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 104.3 сая төгрөгийн алдааг залрууллаа.

### 4.2 Төлбөрийн акт

Байгууллагын дарга нь дээд шатны удирдлагын тушаал шийдвэргүйгээр үр дүнгийн урамшуулал 1.0 сая төгрөгийг илүү тооцон авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 -т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах",, Эрүүл мэндийн яамны 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 1а/3938 албан бичгийн 2-т/Мөнгөн тэтгэмж олгох эрүүл мэндийн байгууллагын үндсэн ажилтнаар томилогдсон байх/" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

### 4.3 Албан шаардлага

Жилийн эцсийн хөрөнгийн тооллого 37.5 сая төгрөгөөр зөрүүтэй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20 дугаар зүйлийн 20.2.6-т "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэн заалттай нийцэхгүй, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
Тус байгууллагын тээвэр шатахууны зардал 26.0 сая төгрөг, түлш халаалтын зардал 20.9 сая төгрөг төсөв батлагдсан хэдий худалдан авах ажиллагаа зарлаагүй нь Төсвийн тухай хуулийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.Монгол улсын Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 124 дүгээр тогтоол гэсэн заалттай нийцэхгүй, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
Жолоочийн замын хуудасгүй, анхан шатны баримтгүйгээр 16.8 сая төгрөгийн шатахууныг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

нийцэхгүй, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Санхүүгийн тайлан, татварын тодорхойлолт 5.2 мянган төгрөгөөр зөрүүтэй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэсэн заалттай нийцэхгүй, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

### 4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн 1 алдаа зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### *1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал*

1.1. Илрүүлэлт Шилэн дансанд байршуулах 58.8 сая төгрөгийн 28 мэдээллээс, 58.8 сая төгрөгийн 6 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл," гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах

1.3. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хөхморьт сумын ЭМТ | 8 | 212.1 | 2 | 104.3 | 1 | 1.0 | 4 | 106.7 | 1 | |
| 5 | Дүн | 8 | 212.1 | 2 | 104.3 | 1 | 1.0 | 4 | 106.7 | 1 | |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ААБ 5.3: АУДИТЫН ЯВЦАД ХИЙСЭН ЗАЛРУУЛГА

Байгууллагын нэр:Хөхморьт сумын ЭМТ
Тайлант хугацаа:2022 он

| Д/Д | Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга | Гүйцэтгэсэн горим сорилын үр дүн (нөхцөл | Мөнгөн дүн | Залруулга хийсэн | | | | Залруулга хийхэд үндэслэл болсон хууль тогтоомж, стандартын нэр, заалт | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Санхүүгийн тайлан | Тодруулга | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан | | |
| А | 1 | 2 | 3.0 | 4.0 | 5.0 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | Зардлыг эдийн засгийн ангилал зөрүүлэн тайлагнасан | | 97,768.5 | 97,768.5 | | | | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15.1-д/.Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна/ | |
| | Нийт залруулгын дүн | | 97,768.5 | 97,768.5 | - | | | | |

Бэлтгэсэн:

Аудитор Э.Сүнжидмаа 2022.02.09
Хянасан:
Аудитын менежер Д.Эрдэнэчимэг 2022.02.09

Танилцаж зөвшөөрсөн

Дарга Л.Баярмаа 2022.02.09

Нягтлан бодогч П.Бадамгарав 2022.02.09

8217144139
ДЮА0060 9018301

Маягт № B501

## Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт

Аудитын нэр: Хөхморьт сумын ЭМТ 2021 оны СТА    Аудитын код: ГАА-2022/340/НА-СТА-ТШ3

Байгууллагын нэр: Хөхморьт сумын ЭМТ

| № | Нөлөөлж буй АГАДҮТ | АГАДҮТ-н дэд анги | Товч утга | Мөнгөн дүн | Материаллаг эсэх | Үр өгөөжөөр | Шалгуур: Стандартын заалт | Шалгуур: Хууль тогтоомжийн заалт | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын | Аудитын байгууллагаас өгсөн | Гаргасан шийдэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Зардал | нийт зардал | Эрүүл мэндийн төвийн дарга нь 1000.0 мянган төгрөгийн урамшуулал цалин авсан байна. | 1,000.0 | 1,000.0 | 1,000.0 | УСНББОУС-1, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.3 | Эрүүл мэндийн яамны 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 1а/3938 албан бичгийн 2/Мөнгөн тэтгэмж олгох эрүүл мэндийн байгууллагын үндсэн ажилтнаар томилогдсон байх/ | Төлбөрийн акт тогтоох | Төлбөрийн акт тогтоох | Төлбөрийн акт тогтоох | Төлбөрийн акт тогтоох |
| 2 | хөрөнгө | нийт хөөнгө | Жилийн эцсийн хөрөнгийн тооллого 37,502.5 Мянган төгрөгөөр зөрүүтэй байна. | 37,502.2 | 37,502.2 | | УСНББОУС-1, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;/, 20.2.6-т /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" | Зөрчил арилгуулах албан шаардлага | хүлээн зөвшөөрсөн | Зөрчил арилгуулах албан шаардлага | Зөрчил арилгуулах албан шаардлага |
| 3 | Зардал | нийт зардал | Тус байгууллагын тээвэр шатахууны зардал 26,000.0 мянган төгрөг, түлш халаалтын зардал 20,946.0 мянган төгрөг төсөв батлагдсан хэдий худалдан авах ажиллагаа зарлагдаагүй байна. | 46,946.0 | | 46,946.0 | УСНББОУС-1, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.5 | Төсвийн тухай хуулийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.Монгол улсын Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 124 дүгээр тогтоол | Зөрчил арилгуулах албан шаардлага | хүлээн зөвшөөрсөн | Зөрчил арилгуулах албан шаардлага | Зөрчил арилгуулах албан шаардлага |
| 4 | Зардал | нийт зардал | Жолоочийн замын хуудасгүй, анхан шатны баримтгүйгээр 16,888.3 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан байна. | 16,888.3 | 16,888.3 | 16,888.3 | УСНББОУС-1, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.6 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" | Зөрчил арилгуулах албан шаардлага | хүлээн зөвшөөрсөн | Зөрчил арилгуулах албан шаардлага | Зөрчил арилгуулах албан шаардлага |
| 5 | Зардал | нийт зардал | Санхүүгийн тайлан, татварын тодорхойлолт 5,256.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. | 5,356.2 | 5,356.2 | | УСНББОУС-1, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.7 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" | Зөрчил арилгуулах албан шаардлага | хүлээн зөвшөөрсөн | Зөрчил арилгуулах албан шаардлага | Зөрчил арилгуулах албан шаардлага |
| 6 | Зардал | нийт зардал | Шилэн дансанд байршуулах 58,800.0 мянган төгрөгийн 28 мэдээллээс, 58,800.0 мянган төгрөгийн 6 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна. | - | | | УСНББОУС-1, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.8 | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, | Зөвлөмж өгөх | хүлээн зөвшөөрсөн | Зөрчил арилгуулах албан шаардлага | Зөрчил арилгуулах албан шаардлага |
| | | | **Нийт дүн** | **106,692.7** | **59,746.7** | **63,834.3** | | | | | | |

107,692.7

Аудитор:    Бэлтгэсэн:    Э.Сүнжидмаа    2022.02.09

Анхан шатанд хянасан: ежер:    Д.Эрдэнэчимэг    2022.02.09

оёр дахь шатанд хянасан: улэх аудитор    Х.Түвшинбаяр    2022.02.09

8217144139
ДЮА0060 9018301

Танилцаж зөвшөөрсөн.

Хөхморьт сумын ЭМТ

Дарга    Л.Баярмаа

Нягтлан бодогч    П.Бадамгарав

Хавсралт 2

| Аудитын нэр: Хөхморьт сумын ЭМТ | | Аудитын менежер: /Д.Эрдэнэчимэг/ | |
|---|---|---|---|
| Аудитын код: ГАА-2022/40/НА-СТА-ТШ3 | | Тэргүүлэх аудитор: /Х.Түвшинбаяр/ | |
| № | Аудитын үр өгөөжийн товч утга | Санхүүгийн үр өгөөж | Санхүүгийн бус үр өгөөж |
| | | (сая төгрөгөөр) | (тоон утгаар) |
| 1 | Эрүүл мэндийн төвийн дарга нь 1000.0 мянган төгрөгийн урамшуулал цалин авсан байна. | 1,000.0 | |
| 2 | Тус байгууллагын тээвэр шатахууны зардал 26,000.0 мянган төгрөг, түлш халаалтын зардал 20,946.0 мянган төгрөг төсөв батлагдсан хэдий худалдан авах ажиллагаа зарлагдаагүй байна. | 46,946.0 | |
| 3 | Жолоочийн замын хуудасгүй, анхан шатны баримтгүйгээр 16,888.3 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан байна. | 16,888.3 | |
| Нийт дүн | | 64,834.3 | - |

Аудитын үр өгөөжийг бүртгэж, хариуцах:
Аудитор: / Э.Сүнжидмаа/
Ахлах аудитор: /Ж.Бужинханд/

Огноо: ...... оны ... сарын ...